

**АЗИЙН “ЗУЛЗАГАН БАР” - МӨНХ НОГООН ВЬЕТНАМ УЛС***“Уусан усныхаа эх ундрааг үргэлж санаж яв”**Б.Гантуяа*

Би 1996 онд, БНСВьетнам Улсын Гадаад худалдааны их сургуульд гадаад худалдаа эдийн засагчийн мэргэжил эзэмшихээр Ханойд очиж суралцсан билээ.

Зүүн Өмнөд Азид, Энэтхэг-Хятадын хойгийн зүүн хойд хэсэгт оршдог энэ гайхамшигт улс орон миний сэтгэлийг маш их татдаг байв.

Вьетнам улс нь 331688 км<sup>2</sup> нутагтай, нутгийн хойноос өмнөд хүртэл 1650 км урт, хамгийн өргөн хэсэг нь 600 км, нарийн хэсэг нь 50 км. Вьетнам улс дулаан орны чийглэг бүгчим халуун уур амьсгалтай, жилд дундчаар 1500 мм тундас унадаг, монгол хүний хувьд дасахад тийм ч амаргүй газар юм. Нэн ялангуяа, халуун улиралд нутгийн аль ч хэсэгт агаарын дулаан +41-50°С хүрэх нь цөөнгүй.

Ханой хотод хамгийн дулаан үе 6-р сард, агаарын дулаан +26-33°С, хамгийн сэрүүн үе 1-р сард +13-20°С байхад, урд зүгийн Хо Ши Мин хотод хамгийн халуун үе 4-р сард +24-38°С болдог ажээ. Вьетнам орон хойт хэсэгтээ сэрүүн уур амьсгалтай, жилийн 4 улиралтай, урд хэсэгтээ маш халуун уур амьсгалтай, борооны ба хуурай гэсэн 2 улиралтай Вьетнам хүмүүсийн яриагаар, Вьетнамын хойд хэсэгт сэрүүний улиралд агаарын дулаан +15°С хүрэхэд тэр өдөртөө хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд явуулахгүй гэрт нь байлгахад хүрдэг. Учир нь Вьетнамд дулааны шугам сүлжээ гэсэн ойлголт байдаггүй. Анх очихдоо Вьетнам орон халуун уур амьсгалтай хэмээн бодож нэлээд нимгэн хувцастай очсон. Гэтэл Вьетнамын сэрүүний улирлын +10°С хэм орчимд нимгэн хувцастай бид нар их даарч байсан нь Вьетнамын чийглэг агаартай холбоотой юм. Вьетнам орны талаар нэлээд их сонсож байсан боловч анхны сэтгэгдэл төсөөлж байснаас үнэхээр өөр байв.

1902 онд анх ашиглалтанд орсон нарийн төмөр зам нь хойт хилийн Донг Данг хотоос Ханой хүртэл 163 км үргэлжилдэг бөгөөд Америкийн эсрэг дайны жилүүдэд хаагдаж байснаа 1994 оноос дахин сэргэсэн байна. Монгол оюутнууд Хятадын хилээс шууд Донг Данг хотод бууж, эндээс Ханой хот хүрдэг.

<sup>\*</sup> Б.Гантуяа - Ханой хотын Гадаад худалдааны их сургуулийн оюутан

Вьетнамын газар нутаг үнэхээр содон өвөрмөц, үзэсгэлэнт байгаль, замд тааралдах хот тосгон, тутрагын талбай, өвдгөө өнгөртөл усанд зогсоод цагаан будааныхаа арвин ургацын төлөө хамаг хүч хөдөлмөрөө зарцуулан хөдөлмөрлөж байгаа тариачдыг харж өөрийн эрхгүй тэдний тэвчээр хатуужил, хөдөлмөрч зан чанарыг нь бахдан биширч явлаа.

Вьетнамын ерөнхийлөгч Хо Ши Мин “Манай хулсны мөн чанар гэвэл вьетнамын ард түмний яс чанартай төстэй. Хулс яс чанартай хатуу мод. Вьетнамчууд тусгаар тогтнолынхоо зорилтонд хулс шигээ хатуу байдаг. Манайд муруй тахир хулс байдаггүй, хулс бол чиг шулуун. Вьетнамчууд тавьсан зорилгондоо хулс шиг чиг шулуун, Хулс бол хөндий, түүний дотор тал цав цагаан. Вьетнам хүний зүрх сэтгэл түүн шигээ ариун цагаан” гэж нэгэнтээ зүйрлэн хэлсэн гэдэг. Вьетнамчууд төрөө их дээдлэн хүндэтгэж, хуулиа хатуу сахидаг, эрэлхэг зоригтой, эх оронч ард түмэн, нэг нь нөгөөгийн төлөө, бие биедээ үнэнч, итгэлтэй, санаа нэгтэй байж чаддаг нь Вьетнам орны өнөөгийн хөгжлийн нэг хүчин зүйл болдог. Вьетнам орон 80-иад сая хүнтэй, үүнээс 36 сая нь хөдөлмөрийн насны хүмүүс байдаг нь эдийн засаг, нийгмийн шинэчлэл, бүтээн байгуулалтыг үр дүнтэй хийх нэг гол нөхцөл болоод байна.

БНСВУ-ын нийслэл Ханой хот мянгаад жилийн түүхтэй /1010 он/, хотын ихэнх хэсэг нь Хонг ба Дай хоёр том мөрний хооронд орших тул “мөрөн доторхи хот” хэмээн нэрлэгддэг.

ЮНЕСКО-гоос хоёр жил тутам дэлхийн 5 бүс нутгаас 5 хотыг сонгон авч “Энх тайваны хот” хүндэт шагналаар өргөмжилдөг уламжлалтай. 1999 онд ЮНЕСКО Ази, Номхон далайн бүс нутгаас Ханой хотыг “Энх тайвны хот” хүндэт шагналаар өргөмжилжээ. 1999 оны судалгаагаар, Ханой хотын гудамж талбай, цэцэрлэг хүрээлэнд 121 төрлийн мод ургадаг бөгөөд, 1 хүнд дунджаар 3,5 м<sup>2</sup> ногоон талбай оногдож байв. 1996 оноос өмнө, Ханой хотод нийтдээ том жижиг 40-ээд нуур байснаас хот тохижуулах явцад нэлээд нуур үгүй болж, одоогоор 20-иод нуур бий.

Жилийн 4 улиралд мөнх ногоон байдаг нийслэл Ханой хотын нийт талбай 9927.39 км<sup>2</sup> 1999 оны байдлаар 2.622.122 хүн амтай. Одоогоос 57 жилийн өмнө, 1945 оны 9-р сарын 2-нд нийслэл Ханой хотын түүхт Ба Динь талбай дээр Вьетнамын ард түмний удирдагч Хо Ши Мин тусгаар тогтнолын тунхаглал уншиж Зүүн Өмнөд Ази дахь ажилчин-тариачины анхны тусгаар тогтносон Вьетнам Улс, өнөөгийн БНСоциалист Вьетнам улсыг үндэслэн байгуулсан билээ.

1945-1954 он хүртэл 9 жил үргэлжилсэн Францын түрэмгийлэгчдийн эсрэг тусгаар тогтнолоо хамгаалах дайн болон 1954-1975 он хүртэл 21 жилийн турш улс орноо нэгтгэх тууштай тэмцэл өрнүүлсэний эцэст 1975 оны 4-р сарын 30-нд Америкийн цэргийн түрэмгийллийг бүрэн зайлуулж Вьетнам орныг нэгтгэсэн түүхэн ялалтыг байгуулсан юм.

Өнөөдөр Вьетнам улс 1986 онд Вьетнамын Коммунист Намын ҮИ их хурлаас дэвшүүлсэн улс орны эдийн засгийг хөгжүүлэх шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, тус улсыг Азийн “Зулзаган бар” болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Вьетнам орны өнөөгийн хөгжлийн гол гол үзүүлэлтээс зарим нэгийг дурьдваас:

2000 онд Вьетнам улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 7% болсон нь 1990 оныхоос хоёр дахин нэмэгджээ. Вьетнамын эдийн засгийн гол тулгуур болох хөдөө аж ахуйн салбарт нийт хүн амын 80% нь ажилладаг. Вьетнамд явуулж буй шинэчлэл, үйлдвэржүүлэлтийн чиг бодлогын үр дүнд цагаан будаа, түүхий эд, нефть, каучук, кофе, төрөл бүрийн жимс зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэх болсноор Ази-Номхон далайн бүс нутаг дахь ХАА-н гаралтай экспортын хувьд хүчтэй өрсөлдөгч орны нэг болжээ. Өнөөгийн Вьетнам улс цагаан будааны экспортоор дэлхийд 2-р байр, цагаан будааны чанараар 5-р байр, Зүүн өмнөд Азийн бүс нутагт цагаан будааны экспортоор тэргүүлж, чанарын хувьд 2-р байрт орж байна. Мөн кофены экспортоор дэлхийн кофе экспортлогч улс орнуудыг даван, Бразилийн дараа 2-р байрт явж байна.

Улс төрийн тогтолцооны хувьд, Вьетнам улс одоо ч социалист орон хэвээрээ, парламентын засаглалтай, ерөнхийлөгчийг парламентаас сонгодог, нэг намын системтэй.

Өнөөдөр, Вьетнам улс санхүү-эдийн засгийн хямралаас нэгэнт гарснаа албан ёсоор мэдэгдэж, 2020 он гэхэд “орчин үеийн шинээр аж үйлдвэржсэн орны эгнээнд орох”, ард түмнээ баян чинээлэг, улсаа хүчирхэг өндөр хөгжилтэй, нийгмээ шударга, ардчилсан, өндөр соёлтой болгох” зорилт тавин түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байна.

Вьетнам улс “дэлхийн олон улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлэх идэвхтэй гадаад бодлого баримталж, дэлхийн 167 улс оронтой дипломат, 150-иад улстай худалдааны харилцаатай байна.

1954 оны 11-р сарын 17-нд Монгол, Вьетнам хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон бөгөөд уламжлалт харилцаатай

манай хоёр улс сүүлийн үед эдийн засаг, улс төр, соёл, шинжлэх ухаан гм олон салбарт харилцааг амжилттай хөгжүүлж, одоогийн байдлаар монголын 50 гаруй компани, эдийн засгийн байгууллага Вьетнамын талтай худалдаа, хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. Монгол Вьетнам хоёр орон цаашид бүтээн байгуулалтын туршлагаа хуваалцаж, уламжлалт найрсаг харилцаа, улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухаан техникийн бүх талын харилцан ашигтай хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлж, Монгол-Вьетнам хоёр орны харилцаа улам батжих болтугай хэмээн билэгт ерөөлөөр энэхүү товч тэмдэглэлээ өндөрлөө.